

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал,Засаг даргын Тамгын газрын
2021 оны 02 дугаар сарын мэдээ

2021.02.26

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлыг хуралдуулж төрийн дээд шагналд 15 иргэнийг тодорхойлж материалыг хүргүүллээ. Мөн малчдын цагаан сараар сум амгийн аварга малчид, аймгийн алдарт уяачдын шагналыг гардуулж сумын хурлын даргын нэрэмжит шагналаар шагнаж урамшууллаа. Тэргүүлэгчдээс 2021 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталлаа.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 28 албан бичиг ирсний 14 нь хариутай 10 –нь хугацаандаа, 4–нь хугацаа болоогүй байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны 05-р сарын 17 ны өдрийн 201 дүгээр захирамжаар баталсан Аймгийн сайн малчны болзол журмыг хангасан 4 малчин өрх, Сумын аварга малчны болзол журмыг хангасан 10 малчин өрхийн материалыг Засаг Даргын Зөвлөлөөр хэлэлцэж материалыг Аймгийн ХХААГазарт хүргүүлж Аймгийн сайн малчин өрх 2, Сумын аварга малчин өрх 9 ийг тодруулж шагналыг гардуулж хүндэтгэл үзүүлсэн.

2021 оны 01 дүгээр сарын 07 –ны өдрийн А/13 тоот захирамжаар 2021 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажил явагдаж дүн мэдээг аймгийн цэргийн штабт 03 дугаар сарын 01-нд хүргүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.

2021 оны 02 дугаар сарын 17 –ны өдрийн А/25 тоот захирамжаар коронавируст халдвар / ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд архи согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 08:00-17:00 цаг байхаар тогтоон, хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг хариуцлагыг бүрэн биелүүлж, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллахыг согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн дарга эрхлэгч нарт үүрэг болгон хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах талаар цагдаагийн тасагт үүрэг өгч ажиллаж байна.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээсэн. Орон нутгийн төсвийн байгууллага, Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу бүрэн олгогдсон.

Аймгаас авах санхүүгийн дэмжлэг, төсвийн орлого төсөв төлөвлөгөөний дагуу санхүүжигдсэн.

Байгууллагын өр авлага, төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн.

Төсөвт байгууллагын няглан бодогч нар 2020 оны жилийн эцсийн тайлан балансыг төрийн аудитаар баталгаажуулсан тайланг Сангийн Яамны цахим санд шивж аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хянан нэгтгүүлэхээр хүргүүлээд байна.

Малын зудын эрсдлээс хамгаалах ТББ тай тэжээлийн гэрээ хийж урьдчилгаа 12390,0 төгрөг шилжүүлж татан авахад бэлэн болоод байна.

Худалдан авах ажиллагааны бүсчилсэн сургалтанд Үнэлгээний хорооны дарга , нарийн бичиг , ОНХ сан хариуцсан нягтлан бодогч нар оролцож байна.

Аймаг, сумын сайн малчин, 1000 –т малчны шагнал дурсгалын зүйлийг захиалан авч төлбөр тооцоог бүрэн хийгдсэн.

Статистикийн байгууллагад хүргүүлэх жилийн эцсийн болон сар улиралын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

2021 онд статистикийн бүтээгдхүүн нийлүүлэх 34 төрлийн мэдээ тайлангийн А/26 тоот захирамж гаргасан.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар мэдээллийг цахимаар иргэдэд тогтмол хүргэж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Ажил хайгч 32 иргэдийн мэдээллийг сэргээсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Сар шинийн баяраар байгууллагын харъяалалгүй 390 ахмадын нэрсийг сумын АДЗ-ийн хурлаар оруулж 390 ахмадын хүндэтгэлд 3900000 төгрөг олгосон.

Хүнсний эрхийн бичгийн 2 сарын олголтыг хийсэн.Тендерт оролцох хүсэлтэй 8 ААНБ-уудад мэдээлэл өгч ажилласан.

Насны хишиг алдарт эхийн одонгийн мөнгө олгохтой холбогдуулан нэр данс зөрүүтэй иргэдийн мэдээллийг Хаан,Төрийн банкттай тулгалт хийн зөрчлийг арилган 440 алдарт эхэд, 196 насны хишиг авах ахмадуудад мөнгийг олголоо.

Халамжийн тэтгэвэр цахимд шилжиж байгаатай холбоотой 74 иргэний дансыг Хаан,Төрийн банкнаас дансыг авч утасны дугаарыг e.halamj.mn цахим системд оруулаад байна.

Сумын хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж холбогдох мэргэжилтэнд цаг хугацаанд хүргүүлсэн.

Сард үйлчилгээ үзүүлж байгаа иргэдээ бүртгэл хөтлөн ажиллаж 42 иргэнд 8 чиглэлээр мэдээлэл өгч ажилласан байна.

Бүрэн дунд сургууль: 1-р ангийн 4 бүлгийн 96 сурагч, 2-р ангийн 3 бүлгийн 96 сурагчдад 2 цагийн математик, монгол хэлний хичээлээр нэг анги 3 ээлжээр буюу 10-с дээшгүй сурагч хамруулж давлага өгч байна.

Мөн 5-р ангийн 3 бүлгийн 87 сурагчидад 2 цагийн давтлага, 9-р ангийн 2 бүлгийн 62 сурагчаас 54 сурагч давтлаганд хамрагдаж , мэргэжлийн 12 багш 6 хичээлээр 2 цагийн давтлага өгч байна.

12-р ангийн 72 сурагчийн 9 хичээлээр 10 мэргэжлийн багшийн ЭЕШ –д бэлтгэх чиглэлээр танхимын давтлага 1 сарын 27 оос эхэлсэн.

Соёл 2021 оны 02сарын 09-нд Соёлын төвийн хамт олны сар шинийн баярт зориулан бэлтгэсэн “Энх мэндийн аялгуу” тоглолтыг Соёлын төвийн болон сумын бусад группүүдээр лайваар шууд дамжуулан үзэгчдэд хүргэлээ.

Аймаг сумын аварга малчдад шагнал гардуулах ёслолын ажиллагаанд Хөгжмийн багш Э.Сэвжидмаа, бүжгийн багш Ц.Амарбаатар нар оролцож урлаг соёлын үйлчилгээ үзүүллээ.

Хүүхдийн цэцэрлэг: Байгууллагын цахим хуудсанд болон бүлгийн дотоод групп чатуудаар хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар 14 зөвлөмж зөвлөгөөг байршуулан нийт 168 хүний хандалт авсан байна.

Бүлгийн багш нар теле хичээлийг тасралтгүй үзүүлэх тал дээр анхаарч эцэг эхчүүдтэй утсаар болон цахимаар холбогдож үзэж чадахгүй байгаа хүүхдийн шалтгааныг тодруулж нөхөж үзүүлэх болон гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн багцыг аялуулж үр дүнг тооцон ажиллаа.

Байгууллагын цахим хурлыг 2 удаа зохион байгууллаа. Хүүхэд хүлээж авах бэлтгэл ажлыг хангаж байгууллагын дотор болон гадна талыг цэвэрлэж ариутгал халдваргүйтлийг хийж бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Үйлдвэрлэл эрхлэгч 16 иргэний төслийг сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцэж 13 иргэний төслийг дэмжин шалгаруулсан.

Сумын Засаг Даргын 2021 оны 02 дугаар сарын 17- ны өдрийн А/25 тоот захирамжийн дагуу цагдаагийн тасагтай хамтран Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй 13 аж ахуй нэгжид хяналт тавин ажиллаж байна.

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийн мэдээг долоо хоног бүрийн 4 дэхь өдөр ХХААГазарт хүргүүлж байна. Сумын аюулгүй нөөцөд 400 боодол өвсийг нэмж татан авсан.

Мал эмнэлэгийн чиглэлээр: ХХААХҮЯ-ны Хяналт шинжилгээ , үнэлгээ, дотоод аудитын газраас зохион байгуулсан Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, боловсруулж батлах, тайлагнах, дүгнэх журмуудын өөрчлөлт болон 2021 оны төлөвлөлт , тайлагналтад анхаарах асуудлууд сэдэвт 2 цагийн цахим сургалтанд ZOOM-оор тасгийн хоёр мэргэжилтэн хамрагдсан.

2020-2021 оны өвөлжилт нь цас ихтэй, хүйтэн, цаг уурын орчны шинжилгээний байгууллагаас гаргасан дүгнэлтээр цагаан зудархуу байдалтай байгаа тул 1 наст төл мал болон тарга тэвээрэг муу авсан малууд, хуц ухна ширвэгдэн хорогдсон. Өнөөдрийн байдлаар сумын хэмжээнд адуу -22, үхэр -65, хонь-621, ямаа-662 бүгд 1370 хорогдсон мэдээтэй байна. Үүнээс хуц -42, ухна-64 хорогдсон. Мөн тэжээлд орсон мал их байгаагаас хордлогын шинжтэй дуудлага 4 удаа ирж түүнд явж үйлчилсэн.

Байгаль орчин: Сумын цаг ууртай хамтран агаарыг бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг явуулж нийт 300 өрхийг Орчны бохирдол аппликейшэнд шивж оруулсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй 5-н ААНэгжүүдийн холбогдох бичиг баримтыг авч БОАЖГазарт хүргүүллээ. Тус суманд үйл ажиллагаа буй 15-н ААН-тэй хог хаягдлын гэрээ байгуулсан. Аргаль хонинд биотехнологийн арга хэмжээ авч ажиллаа.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн